



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар СХМ - 2024/11

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн нэгдсэн музейн
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт
шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Монгол Улсын Соёлын Сайдын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн ХШУДАГ-2024/ДА/14 дугаартай “Соёлын сайд буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын “Санхүүгийн хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Сэлэнгэ аймгийн Музейн үйл ажиллагаанд Монгол улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөрөнгө оруулалт, санхүүгийн мэдээллийг шалган дүгнэх, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга, улсын ахлах байцаагч Т.Одсүрэн ахалж, бүрэлдэхүүнд дотоод аудитор Г.Дорждэрэм нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Соёлын яамны харьяа Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан /цаашид Сэлэнгэ аймгийн Музей/-н 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Сэлэнгэ аймгийн Музей нь улсын бүртгэлийн 9057218 дугаар регистртэй, Төрийн сан дах улсын төсвийн санхүүжилтийн 100130035021, орон нутгийн санхүүжилтийн 100130035010, нэмэлт санхүүжилтийн 100130035402 дугаар данс болон санхүү, татварын баримтад 1-р гарын үсгийг Сэлэнгэ аймгийн Музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярбаатар, 2-р гарын үсгийг Ерөнхий нягтлан бодогч П.Ууганбилэг нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайланг гаргаж ирсэн байна.

1.5 Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей нь бүтэц орон тоог батлаагүй музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS5634:2006 стандартын 1 дүгээр хавсралтад

4324001119

“Музейд шаардлагатай жишиг орон тоо”-ны дагуу удирдах 1, гүйцэтгэх 7, үйлчлэх 6 нийт 14 бүтэц орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Музейн мэргэжилтнүүдийг мэдлэг чадвар нь дээшлүүлэх зорилгоор Хонконг улсад Олон улсын музейн туршлага солилцох сургалт, Дархан уул аймагт эрдэм шинжилгээний бага хурал, Монгол бичгийн сургалт, Нийгмийн даатгалын сургалт зэрэг 4 удаагийн танхимын болон 10 удаагийн зайны сургалтад хамруулсан байна

Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлах газарт 8 ширхэг үзмэрийг сэргээн засварлуулахаар хүргүүлсэн байна.

Үүнд :

1. 82-370 хувийн дугаартай “Тунгийн халбага”
2. 71-1-15 хувийн дугаартай “Хөвхөн гудас”
3. 71-2-26 хувийн дугаартай “Малгай Х.Чойбалсан”
4. 82-290 хувийн дугаартай “Гэлэнгийн цавар”
5. 82-291 хувийн дугаартай “Гэлэнгийн цавар”
6. 85-736 хувийн дугаартай “Хирсний шүд”
7. 82-737 хувийн дугаартай “Зэрлэг үхрийн толгой”
8. 82-720-1 хувийн дугаартай “Савагт хирсний толгой”

Ардын хувьсгалын анхны долоогийн эдэлж хэрэглэж байсан үзмэр, эд өлгийн зүйлс дээр тулгуурлан 2024 оны 02 сарын 02-ны өдөр шинэ танхимыг нээж олон түмний хүртээл болгосон байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Музей нь санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 02 сарын 07-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийн хөтлөн явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу 2024 оны эхний хагас жилийн байдлаар 6,975.4 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлсэн байна.

Соёлын байгууллагын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн журмын дагуу 2023 оны үйл ажиллагааны үр дүнд үндэслэн 22,353.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгосноос албан хаагчдад урамшуулал, эрдэм шинжилгээний сургалтын зардалд 5,241.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим системд эхний хагас жилд нийт 90 мэдээлэл байршуулахаас мэдээлсэн 90 хуулийн хэрэгжилтийг 100% хангасан байна.

Сэлэнгэ аймгийн нэгдсэн Музей нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт хийгдээгүй байна.

2.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 414,507.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 134,143.2 нийт 548,650.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг нийт 224,338.6 мянган төгрөгөөр бууруулж 324,312.1 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Төсвийн саналд нөлөөлөхүйц хэмжээгээр хасагдсан гол зардлуудыг тодруулбал:

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшууллын зардлыг 72,989.8 мянган төгрөг, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 9,123.7 мянган төгрөг, нэг удаагийн урамшууллыг 3,600.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 131,050.0 мянган төгрөг, хангамжийн материалыг 6,729.5 мянган төгрөг, нормативт зардлыг 2,880.0 мянган төгрөг, цэвэр бохир ус болон халаалтын зардлыг 72,258.1 мянган төгрөг, урсгал засварыг 40,000.0 мянган төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэл:

Сэлэнгэ аймгийн нэгдсэн музей 2024 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 177,609.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 34,279.0 мянган төгрөг байгууллагын үйл ажиллагааны орлогоос 10,900.0 мянган төгрөг нийт **222,788.8** мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр хуваарилагдсанаас улсын төсвөөс 177,609.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,809.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, байгууллагын туслах үйл ажиллагаанаас 6,975.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 187,152.3 мянган төгрөг буюу 84.0 хувьтай тайлагнагдсан байна. Үүнийг дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн гүйцэтгэл эхний хагас жилийн байдлаар

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	222,788.8	187,152.3	35,636.5	84.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222,788.8	187,152.3	35,636.5	84.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,035.8	185,425.7	30,610.1	85.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,572.7	127,572.7	-	100.0
210101	Үндсэн цалин	83,946.0	79,830.8	4,115.2	95.1
210102	Нэмэгдэл	23,292.0	26,675.6	(3,383.6)	114.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,444.0	15,540.0	(9,096.0)	241.2
210104	Урамшуулал	13,890.7	5,526.3	8,364.4	39.8
210105	Гэрээт ажлын хөлс	-	-		

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,946.6	15,946.6		100.0
210201	Тэтгэврийн даатгал	10,843.7	10,843.7		100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,275.6	1,275.6		100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	637.9	637.9		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	637.9	637.9		100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,551.5	2,551.5		100.0
2103	Байр ашиглалттай хол тогтмол	29,279.0	25,710.4	3,568.6	87.8
210301	Гэрэл, цахилгаан	3,889.8	1,840.0	2,049.8	47.3
210302	Түлш, халаалт	23,462.6	3,462.6		100.0
210303	Цэвэр, бохир ус	1,926.6	407.9	1,518.7	21.2
2104	Хангамж, бараа материалын зардал	5,890.0	3,352.5	2,537.5	56.9
210401	Бичиг хэрэг	1,400.0	278.9	1,121.2	19.9
210402	Тээвэр, шатахуун	1,400.0	800.0	600.0	57.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	950.0	1,071.0	(121.0)	112.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240.0		240.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,900.0	1,202.7	697.4	63.3
2105	Нормативт зардал	1,000.0		1,000.0	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000.0		1,000.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,841.4	4,152.1	12,689.3	24.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,341.4	-	11,341.4	
210604	Урсгал засвар	5,500.0	4,152.1	1,347.9	75.5
2107	Томилолт, зочны зардал	1,500.0	445.2	1,054.8	29.7
210702	Дотоод албан томилолт	1,500.0	445.2	1,054.8	29.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,206.1	8,246.2	7,959.9	50.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,206.1	7,916.2	7,289.9	52.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600.0		600.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400.0	330.0	70.0	82.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800.0		1,800.0	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800.0		1,800.0	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,753.0	1,726.6	5,026.4	25.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,753.0	1,726.6	5,026.4	25.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,353.0		3,353.0	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,400.0	1,726.6	1,673.4	50.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	222,788.8	215,394.9	7,393.9	96.7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	177,609.8	177,609.9	(0.1)	100.0
1310001	Улсын төсвөөс санхүүжих	177,609.8	177,609.9	(0.1)	100.0

132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,279.0	30,809.6	3,469.4	89.9
1320001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,279.0	30,809.6	3,469.4	89.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,900.0	6,975.4	3,924.6	64.0

Эх сурвалж: Аймгийн нэгдсэн музейн санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.3. Мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдэл, тайлан гаргалт, Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагын данс бүртгэлд тусгасан эсэх, санхүүгийн үйл ажиллагааны явц, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Батлагдсан төсөв:

2024 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвөөс 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 215,394.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,999.5 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,863.3	45,105.8	28,242.5
Авлага	-	1,217.0	1,217.0
Бараа материал	65,365.4	66,587.3	1,221.9
Үндсэн хөрөнгө	3,715,022.4	3,669,341.5	(45,680.9)
Нийт хөрөнгө	3,797,251.1	3,782,251.6	(14,999.5)
Өр төлбөр	-	14,726.3	14,726.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,797,251.1	3,767,525.3	(29,725.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,797,251.1	3,782,251.6	(14,999.5)

Эх сурвалж: Аймгийн нэгдсэн музейн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

- ✓ 2024 онд авлага дансанд М.Баярбаатар нь 2024 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх ээлжийн амралтын тооцоог хийж олгосон 1,217.0 мянган төгрөгийг бүртгэсэн байна.
- ✓ 14,726.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн гол шалтгаан нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлснээс, хувийн хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын 1,693.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл (НДШ)-ийн 13,033.2 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Цалингийн өр төлбөр үүссэн талаар Соёл урлагийн газарт 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар албан тоотоор мэдэгдэж байсан боловч хариу ирүүлээгүй байна.

- ✓ Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 45,680.9 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
- ✓ Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 1,221.9 мянган төгрөгөөр өссөн нь 13,321.9 мянган төгрөгийн /сургалтын бичиг хэрэг, цайны болон барилгын засварын материал гэх мэт/ бараа материалыг худалдан авч 12,100.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна.

Анхан шатны баримтын бүрдэл

Анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад хууль, журмын дагуу бүрдэл хангагдсан байна.

Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар Сэлэнгэ аймгийн Музейн албан хаагчдын цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд Сэлэнгэ аймгийн Музейн ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

ЭЗКод	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Тооцсон цалин	/хэтрэлт - , хэмнэлт+/ Хувь	Хувь
210101	Үндсэн цалин	83,946.0	90,793.7	(6,847.7)	108.2
210102	Нэмэгдэл цалин	23,292.0	30,228.8	(6,936.8)	129.8
210103	Урамшуулал	6,444.0	15,540.0	(9,096.0)	241.2
210104	Унаа, болон бусад нөхөн олговор	13,890.7	5,526.3	8,364.4	39.8
Цалин хөлс нэмэгдэл дүн		127,572.7	142,088.8	(14,516.1)	111.4
210201	Тэтгэврийн даатгал	10,843.7	11,510.9	(667.2)	106.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,275.6	1,359.8	(84.2)	106.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	637.9	670.0	(32.1)	105.0
210204	Ажилгүйдлийн даатгал	637.9	491.3	146.6	77.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,551.5	2,124.8	426.7	83.3
Ажил олгогчоос төлөх НДШ		15,946.6	16,156.8	(210.2)	101.3
Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн		143,519.3	158,245.6	(14,726.3)	110.3
Орон тооны мэдээлэл		14	14		

Сэлэнгэ аймгийн нэгдсэн музейн ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс

хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахад нийт 14 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж эхний хагас жилийн байдлаар цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд нийт 143,519.3 мянган төгрөгийн зарцуулалтын эрх тавигдсанаас гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-д нийт 158,245.6 мянган төгрөгийн зардал тайлагнагдсан нь 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс төрийн албан хаагчдын цалин хөлсийг 10 хувиар нэмэгдүүлсэн санхүүжилтийг олгоогүйгээс НДШ-д, ХХОАТ-ын өр төлбөр үүссэн байна.

2.4 Өмнө хийгдсэн аудит, шалгалтаар илэрсэн зөрчлийн, төлбөр зөрчил түүний барагдуулалт

Хүснэгт 11.

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн шийдвэрлэлт	2023 он				
	Үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Албан шаардлага	1	1,182.6	1	1,182.6	100.0
Нийт дүн	1	1,182.6	1	1,182.6	100.0

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн хяналт шалгалтаар 2023 онд батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 1,182.6 мянган төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж зөрчлийг ажилласан байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн нэгдсэн музейн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

Илрүүлэлт 1. Албан томилолтоор ажилласан 3 албан хаагчийн унаа, хоолны хөнгөлөлт 80.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" 2.2 дах "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.3 дах "хоолны зардал" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Албан хаагч нарт давхардуулан олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг суутган тооцох **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс ажилчидтай холбоотой ХХОАТ-ын 1,693.1 мянган төгрөг, НДШ-ийн 13,033.2 мянган төгрөг нийт 14,726.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Дээд шатны төсвийн захирагчийн баталсан төсвийн хүрээнд ажиллаж үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулж зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Байгууллагын туслах үйл ажиллагаанаас бий болох орлогыг төсөв батлахаас өмнө төлөвлөж батлаагүй атал төсвийн жилийн дундуур 6,975.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Байгууллагын туслах үйл ажиллагаанаас бий болох орлогыг хууль, эрхийн актад нийцүүлэн иж бүрэн, үнэн зөв төлөвлөж баталж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн нэгдсэн музейн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны эхний хагас жилийн санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Бага" эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймгийн нэгдсэн музейн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 14,806.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 14,806.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэх, Байгууллагын туслах үйл ажиллагаанаас би болох төсвийн орлогыг хууль, эрхийн актад нийцүүлэн иж бүрэн, үнэн зөв төлөвлөж байх 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын захирал, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.


Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус газрын захирал, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгагдагч байгууллагаас хяналт шалгалтай холбоотойг санал, тайлбар гаргаагүй шалгалтаар илэрсэн 14,806.2 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүлээн зөвшөөрсөн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 12 дүгээр сарын 15-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус газрын захирал, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ
ДОТООД АУДИТОР



Г.ДОРЖДЭРЭМ

ТАНИЛЦСАН:

